



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ХУРАЛДААНЫ
ТЭМДЭГЛЭЛЭЭС

2019 оны 06 сарын 18 өдөр

Дугаар 14

Улаанбаатар хот

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 06 дугаар сарын 18-ны өдрийн 14 дүгээр хуралдааны тэмдэглэлд:

XI. ХЭЛЭЛЦСЭН НЬ:


Нийслэлийн Сүхбаатар дүүргийн 1 дүгээр хорооны нутаг дэвсгэрт байрлах Цагдаагийн ерөнхий газрын Тээврийн цагдаагийн алба (хуучнаар Замын цагдаагийн газар)-ны үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, 5 барилга байгууламжийг худалдах нээлттэй дуудлагын худалдааны явцын тухай.

ШИЙДВЭРЛЭСЭН НЬ:

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 02 дугаар сарын 19-ний өдрийн 59 дүгээр тогтоолоор нийслэлийн Сүхбаатар дүүргийн 1 дүгээр хорооны нутаг дэвсгэрт байрлах Цагдаагийн ерөнхий газрын Тээврийн цагдаагийн алба (хуучнаар Замын цагдаагийн газар)-ны үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, 5 барилга байгууламжийн нээлттэй дуудлагын худалдааны анхны үнийг 17,333,000,000.00 (Арван долоон тэрбум гурван зуун гучин гурван сая) төгрөгөөр тогтоож, нээлттэй дуудлагын худалдааг 2019 оны 03 дугаар сарын 27, 04 дүгээр сарын 17-ны өдөр зохион байгуулахад нэг ч оролцогч саналаа ирүүлээгүй.

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 04 дүгээр сарын 30-ны өдрийн 121 дүгээр тогтоолоор анхны үнийг 20 хувь бууруулж, 13,867,800,000.00 (арван гурван тэрбум найман зуун жаран долоон сая найман зуун мянган) төгрөгөөр шинэчлэн тогтоож, 2019 оны 05 дугаар сарын 24, 06 дугаар сарын 12-ны өдөр нээлттэй дуудлагын худалдааг зохион байгуулахад нэг ч санал ирүүлээгүй байна.

Тээврийн цагдаагийн албаны 5 барилга байгууламжийн нээлттэй дуудлагын худалдааг 4 удаа зохион байгуулахад нэг ч оролцогч санал ирүүлээгүй тул хувьчлах тухай асуудлыг түр хойшлуулах, тус барилгыг өөр зориулалтаар ашиглах, шинээр барилга барихад шаардагдах хөрөнгийг 2020 оны Улсын төсөвт суулгах тухай асуудлыг Засгийн газарт танилцуулж, чиглэл авахыг Бодлого төлөвлөлт, удирдлагын хэлтэс (Ц.Баяр-Эрдэнэ)-т даалгав”... гэжээ.



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗАР

000045